**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 10 өдөр | Дугаар А/478 | Булган сум

Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Монгол Улсын хөгжлийн бодлого хэрэгжилт, Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" сэдэвт богино хугацааны сургалтыг сум, байгууллагын холбогдох ажилтан, албан хаагчдыг хамруулан 2024 оны 11 дүгээр 18, 19-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталж, 3,500,400 (гурван сая таван зуун мянга дөрвөн зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 10-ны/ний өдрийн А/998 дугаар
захирамжийн хавсралт

# ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ
## СУРГАЛТЫН ТӨСӨВ

| Д/Д | Нэр | Нэгж үнэ | Тоо/ширхэг | Нийт төсөв |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Өдрийн хоол, цай | 20,000 | 47 | 940,000 |
| 2 | Цайны завсарлага | 6850*2 удаа | 58 | 794,000 |
| 3 | Цай кофе | 1600*3 удаа | 58 | 278,400 |
| 4 | Оройн хоол | 24000 | 62 | 1,488000 |
| Нийт зардал | | | | 3,500,400 |